

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/23/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер Э.Энхбаатар Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Ахлах аудитор О.Баярмаа Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	17
3.5.3 Нэмэлт төсөв	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Албан шаардлага.....	23
5.3 Зөвлөмж	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ОББҮХ	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.БАТБАЯР ТАНАА

2026.02.25 № 06/348
танай _____-ны № _____-т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын сөрөг дүгнэлтийн суурь болоход хангалттай бөгөөд зохистой гэдэгт итгэж байна.

- Төсвийн шууд захирагчийн 2024 оны аудит хийсэн санхүүгийн тайлангийн жилийн эцсийн үлдэгдлээс 2025 оны эхний үлдэгдлийг 959,456.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/225 дугаар тушаалаар ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд төсөвт тусгаагүй, тооцоо судалгаагүй "Хашаандаа 5 мод таръя" аяныг зохион байгуулахад нийт 5,000,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар баталж, тендер сонгон шалгаруулалтгүй 265 аж ахуйн нэгжтэй мод тарих, 10 аж ахуйн нэгжтэй хяналт тавих, 7 аж ахуйн нэгжтэй сургалт зохион байгуулах 16,000.0-18,704.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, гүйцэтгэл гараагүй байхад гэрээний нийт дүнгийн 70.0 хувь буюу 3,507,184.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон, мөн 308,280.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан 25 аж ахуйн нэгж байгууллага нь гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн;
- Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас төсвийн төсөлд тусгаагүй, худалдан ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй, зөөврийн ариун цэврийн байгууламж барих ажил үйлчилгээг ажлыг гүйцэтгүүлж, нийт 1,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон, мөн зүгшрүүлэх, тохируулах хугацааны чанарын баталгааны 5.0 хувь буюу 50,000.0 мянган төгрөгийн барьцааг байршуулаагүй;

- Судалгаа болон харьцуулалтгүй онгоцны тийзийн үйлчилгээ, зуучлан борлуулдаг 6 аж ахуйн нэгж байгууллагатай шууд гэрээ байгуулж, тийзийн төлбөрт нийт 576,937.2 мянган төгрөгийг шилжүүлсэн;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг хүлээн зөвшөөрч гадаад арга хэмжээний зардалд 82,069.0 мянган төгрөг, гадаад томилолтын тийзийн төлбөрийг давхардуулан шилжүүлсэн 42,934.0 мянган төгрөг, бусад байгууллагын ажилтны гадаад томилолтын зардалд 140,245.7 мянган төгрөг, нийт 265,248.7 мянган төгрөгийг зарцуулсан;
- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/231 дүгээр тушаалаар ойжуулалтын хөтөлбөрөөс тендер сонгон шалгаруулалтгүй 32 хэвлэл, мэдээллийн байгууллагатай шууд гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 226,114.00 мянган төгрөг, нийт 265,248.7 мянган төгрөгийг олгосон;
- Дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд өмнөх онуудад агаар, орчны бохирдлыг бууруулахаар нэр бүхий 6 аймгийн сумд, Нийслэлийн Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлсэн аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулах барих ажлын 1,386,778.1 мянган төгрөг, лаг шатаах үйлдвэр барих ажлын 406,104.7 мянган төгрөг, нийт 1,792,882.8 мянган төгрөгийн дуусаагүй ажлын үлдэгдэлтэй, гэрээний хугацаа дууссан боловч гэрээт ажлыг дуусгуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй;
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/47 дугаар тушаалаар Богдхан уулын дархан цаазат газрын Нүхтийн амны хязгаарлалтын бүсэд байрлах 3.9 га газрыг "Цөлжилттэй тэмцэх Монгол-Хятадын хамтын ажиллагааны төв"-ийг байгуулах зорилгоор ашиглах эрхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд олгосон боловч яамны данс бүртгэлд тусгаагүй;
- Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй худгийн 3 байшин, газар доорх зоорь, гүний худаг, ёмкость, техникийн байшин, ариун цэврийн байгууламж зэрэг 10 нэр төрлийн 503,285.1 мянган төгрөгийн хөрөнгө оршин байгаа нь тодорхойгүй, жилийн эцсийн тооллогоор биетээр тоологдоогүй зэрэг зөрчил илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.7, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.1, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 15 дугаар зүйлийн 15.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.10, 42 дугаар зүйлийн 42.1, 42.5 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос өмнөх онуудад хэрэгжүүлсэн гэр хорооллын 5012 өрхийг 4 квт цахилгаан халаагуур ашиглах техникийн боломж бүрдүүлэх Багц: 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 10, 11, 12 эрчим хүчний ажлын, мөн аймгуудын Дулаан цахилгаан станцын шүүлтүүр суурилуулах болон зуухны яндангийн утааны шүүлтүүр, цонхны шүүлтүүр нано тор, газрын гүний дулааны насос, нам даралтын зуухыг хийн зуухаар солих, аймгуудын нам даралтын зуухны утаа шүүгч зэрэг нийт 33,096,657.7 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг хүлээн авч ашиглагч байгууллагуудад шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос өмнөх онуудад хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний үр дүнг дүгнээгүй, дуусаагүй асуудал давтагдан гарч байхад ижил төстэй арга хэмжээг хөтөлбөрийн зардлаас зарцуулж байгаад дээд шатны захирагч болон түүний дэргэдэх дотоод аудитын алба анхаарах.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Засгийн газрын 2025 оны 36 дугаар тогтоолоор Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад үүрэг болгосны дагуу Цөлжилттэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулах Үндэсний хорооны ажиллах дүрэм, ажлын албаны бүтэц, орон тоо, чиг үүрэг, төсөв, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг баталсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2026\0225 SAG-41.Docx

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	64,395,270,794.19	23,988,986,192.78
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,496,302,323.86	2,823,381,500.55
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,496,302,323.86	2,823,381,500.55
31210	Төгрөг	3,496,302,323.86	2,823,381,500.55
31211	Төрийн сангийн харилцах	3,496,302,323.86	2,823,381,500.55
33	АВЛАГА	458,515,767.17	553,793,889.24
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	50,916,635.88	9,528,485.37
33300	Татаас санхүүжилтийн авлага	-	130,006,272.58
33500	Бусад авлага	407,599,131.29	414,259,131.29
33510	Байгууллагаас авах авлага	352,015,294.30	358,675,294.30
33520	Хувь хүмүүсээс авах авлага	55,583,836.99	55,583,836.99
34	УРЬДЧИЛГАА	17,066,503,439.48	15,929,562,756.04
34600	Урьдчилж гарсан зардал	17,066,503,439.48	15,929,562,756.04
35	БАРАА МАТЕРИАЛ	8,815,425,646.70	3,231,401,753.62
35100	Түүхий эд материал	46,055,960.00	22,226,600.00
35110	Тусгай зориулалттай материал	46,055,960.00	22,226,600.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	7,315,343,514.94	1,792,882,760.10
35400	Хангамжийн материал	1,454,026,171.76	1,416,292,393.52
35410	Бичиг хэргийн материал	47,271,940.00	8,145,900.00
35420	Аж ахуйн материал	55,053,581.00	21,083,394.00
35430	Сэлбэг хэрэгсэл	654,500.00	4,000,000.00
35440	Түлш, шатах тослох материал	10,393,491.76	20,666,000.00
35450	Барилгын засварын материал	6,563,000.00	6,468,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,334,089,659.00	1,355,929,099.52
36	НӨӨЦИЙН БАРАА	34,558,523,616.98	1,450,846,293.33
36600	Бусад нөөц	12,663,825.00	1,644,200.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	34,545,859,791.98	1,449,202,093.33
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,050,551,176.94	6,205,375,990.23
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,050,551,176.94	6,205,375,990.23
39100	Газар	132,825,000.00	132,825,000.00
39200	Биет хөрөнгө	4,979,056,301.62	5,067,514,938.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	816,688,253.50	816,688,253.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(61,251,618.96)	(81,668,825.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	939,029,480.00	508,206,440.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(596,072,263.35)	(175,414,630.27)
39205	Машин тоног төхөөрөмж	4,856,492,177.47	4,579,237,165.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,753,409,704.89)	(2,365,469,784.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	475,049,018.62	380,393,200.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	(234,043,274.06)	(127,356,550.18)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,174,000,000.00	1,174,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	650,740,212.50	656,940,212.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(288,165,979.21)	(298,040,544.13)
39300	Биет бус хөрөнгө	938,669,875.32	1,005,036,052.10
39301	Програм хангамж	2,893,200.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,854,366.62)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	944,629,049.00	1,012,517,789.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(6,998,007.06)	(7,481,736.90)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	70,445,821,971.13	30,194,362,183.01
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,972,999,600.80	7,192,090,013.35
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,972,999,600.80	7,192,090,013.35
41300	Өглөг	4,444,440,134.65	4,368,708,512.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	(0.01)	169,383,609.61
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	13,692,800.00	13,692,800.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	2,574,075,122.16	2,535,234,956.16
41360	Бусад өглөг	1,856,672,212.50	1,650,397,147.03

41361	Байгууллагад төлөх өглөг	1,814,803,290.50	1,649,872,774.03
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	41,868,922.00	524,373.00
41400	Урьдчилж орсон орлого	2,528,559,466.15	2,823,381,500.55
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	2,528,559,466.15	2,823,381,500.55
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	63,472,822,370.33	23,002,272,169.66
51	Засгийн газрын хувь оролцоо	63,472,822,370.33	23,002,272,169.66
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,881,171,779.25	3,881,171,779.25
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	3,881,171,779.25	3,881,171,779.25
51200	Хуримтлагдсан үр дүн	59,571,453,516.95	19,115,721,918.51
51210	Өмнөх үеийн үр дүн	59,571,453,516.95	59,117,543,796.74
51220	Тайлант үеийн үр дүн		(40,001,821,878.23)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,197,074.13	5,378,471.90
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	70,445,821,971.13	30,194,362,183.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	38,632,240,490.84	15,865,538,598.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,231,625,798.00	15,052,727,302.53
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	36,207,819,543.00	14,266,814,416.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,207,819,543.00	14,266,814,416.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,806,255.00	785,912,886.53
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	23,806,255.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	785,912,886.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,400,614,692.84	812,811,295.83
1200	Нийтлэг татварын бус орлого	2,400,614,692.84	812,811,295.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,950,000.00	2,276,394.76
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,950,000.00	2,276,394.76
120009	Бусад орлого	1,271,117,086.15	4,938,534.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,087,764,943.41	799,384,650.55
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	36,782,663.28	6,211,716.52
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	27,052,735,853.99	17,168,333,119.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,052,735,853.99	17,168,333,119.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,173,245,522.07	16,357,798,804.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,643,047,019.61	6,168,639,110.18
210101	Үндсэн цалин	3,050,439,861.95	3,920,831,063.73
210102	Нэмэгдэл	838,701,908.31	1,026,623,546.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	408,507,449.35	814,376,000.00
210104	Урамшуулал	345,397,800.00	406,808,500.00
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	561,863,308.50	789,304,714.44
210201	Тэтгэврийн даатгал	385,647,724.47	552,334,009.79
210202	Тэтгэмжийн даатгал	49,763,697.68	62,442,881.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,161,001.54	32,515,853.72
210204	Ажилгүйдлийн даатгал	17,716,910.93	28,369,276.14
210205	Эрүүл мэндийн даатгал	84,573,973.88	113,642,693.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,130,647.91	139,612,958.00
210301	Гэрэл, цахилгаан	27,311,347.91	2,256,148.00
210302	Түлш, халаалт	13,742,300.00	
210303	Цэвэр, бохир ус	6,077,000.00	92,400.00
210304	Байрны түрээс	-	137,264,410.00
2104	Хангамж, бараа материалын зардал	348,837,330.34	325,059,793.43
210401	Бичиг хэрэг	112,838,897.00	88,533,305.00
210402	Тээвэр, шатахуун	121,009,140.00	61,957,838.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	74,700,428.54	89,947,577.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,682,761.00	83,095,047.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,372,740.00	882,000.00
210408	Бараа материал акталсны зардал	23,233,363.80	644,025.00
2105	Нормативт зардал	7,249,133.00	-
210502	Хоол, хүнс	7,249,133.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,164,650.00	39,357,085.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,724,000.00	16,074,785.00
210602	Тавилга	-	115,000.00
210604	Урсгал засвар	95,440,650.00	23,167,300.00
2107	Томилолт, зочны зардал	245,021,996.40	635,336,912.30
210701	Гадаад албан томилолт	-	554,677,577.60
210702	Дотоод албан томилолт	245,021,996.40	80,659,334.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,582,675,058.82	7,570,677,736.28

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,526,900,765.82	7,550,653,989.28
210803	Даатгалын үйлчилгээ	498,960.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,226,476.00	1,755,097.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,963,063.00	18,092,650.00
210807	Газрын төлбөр	27,952,794.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	638,256,377.49	689,810,495.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,592,000.00	9,998,540.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,300,000.00	3,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	630,364,377.49	676,811,955.35
212	ТАТААС	45,017,099.00	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох	45,017,099.00	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох	45,017,099.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,834,473,232.92	810,534,314.21
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	100,367,130.00	281,470.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	281,470.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	100,367,130.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	525,782,886.00	184,735,250.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	725,328.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	97,058,180.00	37,405,250.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	87,150,000.00	108,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,849,378.00	38,830,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	246,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,208,323,216.92	625,367,594.21
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,208,323,216.92	536,489,389.03
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		88,878,205.18
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	150,000.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт		150,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	11,579,504,636.85	(1,302,794,520.83)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,660,461,297.82	38,699,027,357.40
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,165,110.26	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,657,540,437.56	38,625,590,475.49
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	73,436,881.91
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	755,750.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(2,660,461,297.82)	(38,699,027,357.40)
5	НИЙТ ҮР ДҮН	8,919,043,339.03	(40,001,821,878.23)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	38,016,234,698.46	15,274,110,503.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,241,671,768.00	15,266,103,575.11
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	36,217,865,513.00	14,266,814,416.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	36,217,865,513.00	14,266,814,416.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,806,255.00	999,289,159.11
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	23,806,255.00	17,148,325.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	785,912,886.53
131105	Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	196,227,947.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,774,562,930.46	8,006,928.76
1200	Нийтлэг татварын бус орлого	1,774,562,930.46	8,006,928.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,950,000.00	2,276,394.76
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,950,000.00	2,276,394.76
120009	Бусад орлого	1,769,612,930.46	5,730,534.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,462,117,268.65	15,947,031,327.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,462,117,268.65	15,947,031,327.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,488,319,959.78	15,004,184,398.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,652,714,766.98	5,883,608,741.89
210101	Үндсэн цалин	3,073,881,294.56	3,205,692,843.84
210102	Нэмэгдэл	800,062,197.99	1,432,829,444.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	439,389,840.00	807,189,897.09
210104	Урамшуулал	339,381,434.43	437,896,556.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	622,265,226.77	861,667,758.38
210201	Тэтгэврийн даатгал	530,648,863.91	571,804,013.60
210202	Тэтгэмжийн даатгал	30,598,715.74	84,577,287.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,046,867.32	50,716,057.31
210204	Ажилгүйдлийн даатгал	9,967,765.96	31,045,116.17
210205	Эрүүл мэндийн даатгал	40,003,013.84	123,525,284.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,130,647.91	104,525,478.00
210301	Гэрэл, цахилгаан	27,311,347.91	28,629,668.00
210302	Түлш, халаалт	13,742,300.00	
210303	Цэвэр, бохир ус	6,077,000.00	92,400.00
210304	Байрны түрээс		75,803,410.00
2104	Хангамж, бараа материалын зардал	215,569,132.54	205,875,774.67
210401	Бичиг хэрэг	45,981,700.00	48,430,330.00
210402	Тээвэр, шатахуун	88,044,000.00	45,809,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	73,906,032.54	100,281,927.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,637,400.00	11,354,177.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	137,810,932.00	115,036,710.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	42,624,082.00	64,591,410.00
210602	Тавилга		26,278,000.00
210604	Урсгал засвар	95,186,850.00	24,167,300.00
2107	Томилолт, зочны зардал	213,088,000.60	724,928,010.30
210701	Гадаад албан томилолт	-	636,668,675.60
210702	Дотоод албан томилолт	213,088,000.60	88,259,334.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,485,547,274.98	7,067,398,485.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,413,178,444.98	7,032,078,538.15
210803	Даатгалын үйлчилгээ	498,960.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,242,676.00	5,555,097.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	40,541,400.00	29,588,850.00

210807	Газрын төлбөр	27,952,794.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,193,978.00	41,143,440.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,238,678.00	38,143,440.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,955,300.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,973,797,308.87	942,846,928.79
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	247,500,414.00	5,163,062.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	247,350,414.00	5,163,062.00
213105	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн шилжүүлэг	150,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	515,146,000.95	182,310,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	88,396,622.95	33,780,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	85,900,000.00	109,700,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,849,378.00	38,830,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	246,000,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,211,150,893.92	755,373,866.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,208,323,216.92	536,489,389.03
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,827,677.00	218,884,477.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,554,117,429.81	(672,920,823.31)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	733,746,139.15	-
	Дотоод эх үүсвэрээр	733,746,139.15	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(733,746,139.15)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	820,371,290.66	(672,920,823.31)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,675,931,032.60	3,496,302,323.86
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,496,302,323.86	2,823,381,500.55

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,881,171,779.25	25,934,867.61	50,646,672,384.44	54,553,779,031.30
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			5,737,793.48	5,737,793.48
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,881,171,779.25	25,934,867.61	50,652,410,177.92	54,559,516,824.78
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		(5,737,793.48)		(5,737,793.48)
Тайлант үеийн үр дүн			8,919,043,339.03	8,919,043,339.03
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,881,171,779.25	20,197,074.13	59,571,453,516.95	63,472,822,370.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(453,909,720.21)	(453,909,720.21)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,881,171,779.25	20,197,074.13	59,117,543,796.74	63,018,912,650.12
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(14,818,602.23)		(14,818,602.23)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн			(40,001,821,878.23)	(40,001,821,878.23)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,881,171,779.25	5,378,471.90	19,115,721,918.51	23,002,272,169.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	20,244,417,700.00	13,730,948,438.97	6,513,469,261.03	67.8
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20,244,417,700.00	13,730,948,438.97	6,513,469,261.03	67.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,244,417,700.00	13,730,948,438.97	6,513,469,261.03	67.8
Улсын төсвөөс санхүүжих	20,244,417,700.00	13,730,948,438.97	6,513,469,261.03	67.8
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,244,417,700.00	13,730,948,438.97	6,513,469,261.03	67.8
УРСГАЛ ЗАРДАЛ	20,244,417,700.00	13,730,948,438.97	6,513,469,261.03	67.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,859,682,000.00	13,543,475,376.97	6,316,206,623.03	68.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,460,844,400.00	5,352,023,000.53	108,821,399.47	98.0
Үндсэн цалин	2,819,881,900.00	2,858,175,343.93	(38,293,443.93)	101.4
Нэмэгдэл	1,427,642,500.00	1,300,414,017.62	127,228,482.38	91.1
Унаа хоолны хөнгөлөлт	756,142,600.00	771,201,757.64	(15,059,157.64)	102.0
Урамшуулал	457,177,400.00	422,231,881.34	34,945,518.66	92.4
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	994,704,900.00	805,985,583.39	188,719,316.61	81.0
Тэтгэврийн даатгал	735,910,800.00	539,931,211.07	195,979,588.93	73.4
Тэтгэмжийн даатгал	76,570,300.00	78,449,372.70	(1,879,072.70)	102.5
ҮОМШӨ-ний даатгал	46,715,300.00	47,754,604.99	(1,039,304.99)	102.2
Ажилгүйдлийн даатгал	27,101,700.00	27,970,082.91	(868,382.91)	103.2
Эрүүл мэндийн даатгал	108,406,800.00	111,880,311.72	(3,473,511.72)	103.2
Байр ашиглалттай холбоотой зардал	179,780,100.00	102,457,630.00	77,322,470.00	57.0
Гэрэл, цахилгаан	51,811,400.00	26,561,820.00	25,249,580.00	51.3
Түлш, халаалт	18,906,900.00	-	18,906,900.00	-
Цэвэр, бохир ус	23,264,300.00	92,400.00	23,171,900.00	0.4
Байрны түрээс	85,797,500.00	75,803,410.00	9,994,090.00	88.4
Хангамж, бараа материалын зардал	209,273,600.00	181,734,956.67	27,538,643.33	86.8
Бичиг хэрэг	45,785,500.00	33,822,930.00	11,962,570.00	73.9
Тээвэр, шатахуун	45,809,300.00	45,809,340.00	(40.00)	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	102,039,300.00	90,748,509.67	11,290,790.33	88.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,639,500.00	11,354,177.00	4,285,323.00	72.6
Эд хогшил, урсгал засварын зардал	46,524,000.00	44,203,710.00	2,320,290.00	95.0
Багаж, техник, хэрэгсэл	20,950,000.00	20,036,410.00	913,590.00	95.6
Урсгал засвар	25,574,000.00	24,167,300.00	1,406,700.00	94.5
Томилолт, зочны зардал	795,369,600.00	698,629,918.30	96,739,681.70	87.8
Гадаад албан томилолт	703,365,300.00	610,370,583.60	92,994,716.40	86.8
Дотоод албан томилолт	92,004,300.00	88,259,334.70	3,744,965.30	95.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,131,486,700.00	6,317,297,138.08	5,814,189,561.92	52.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,998,426,400.00	6,281,977,191.08	5,716,449,208.92	52.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,225,200.00	-	3,225,200.00	-
Даатгалын үйлчилгээ	1,971,000.00	-	1,971,000.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	5,555,100.00	5,555,097.00	3.00	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	322,900.00	176,000.00	146,900.00	54.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	93,579,300.00	29,588,850.00	63,990,450.00	31.6
Газрын төлбөр	28,371,000.00	-	28,371,000.00	-
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	35,800.00	-	35,800.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	41,698,700.00	41,143,440.00	555,260.00	98.7
Бараа үйлчилгээний бусад зардал	38,698,700.00	38,143,440.00	555,260.00	98.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	384,735,700.00	187,473,062.00	197,262,638.00	48.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	153,526,800.00	5,163,062.00	148,363,738.00	3.4
Засгийн газрын гадаад шилжүүлэг	153,526,800.00	5,163,062.00	148,363,738.00	3.4
Бусад урсгал шилжүүлэг	231,208,900.00	182,310,000.00	48,898,900.00	78.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	45,780,000.00	33,780,000.00	12,000,000.00	73.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	146,570,200.00	109,700,000.00	36,870,200.00	74.8
Тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн тэтгэмж	38,858,700.00	38,830,000.00	28,700.00	99.9
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
Төсвийн байгууллага	1	1	-	
АЖИЛЛАГСДЫН ТОО	122	111	11	91.0
Удирдах ажилтан	21	15	6	71.4
Гүйцэтгэх ажилтан	101	96	5	95.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ОРЛОГЫН ДҮН		999,289,159.11
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		17,148,325.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		785,912,886.53
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		196,227,947.58
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		999,289,159.11
А. УРСГАЛ ЗАРДАЛ		999,289,159.11
1. БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		793,977,674.35
1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		531,585,741.36
Үндсэн цалин		347,517,499.91
Нэмэгдэл		132,415,427.00
Унаа хоолны хөнгөлөлт		35,988,139.45
Урамшуулал		15,664,675.00
1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		55,682,174.99
Тэтгэврийн даатгал		31,872,802.53
Тэтгэмжийн даатгал		6,127,914.44
ҮОМШӨ-ний даатгал		2,961,452.32
Ажилгүйдлийн даатгал		3,075,033.26
Эрүүл мэндийн даатгал		11,644,972.44
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал		206,709,758.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,067,848.00
Хангамж, бараа материалын зардал		24,140,818.00
Эд хогшил, урсгал засварын зардал		70,833,000.00
Томилолт, зочны зардал		26,298,092.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		83,370,000.00
2. УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		205,311,484.76
Олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		205,311,484.76
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь үйл ажиллагааны зорилгоо “Байгаль хамгаалах нэгдмэл удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хүрээлэн байгаа орчны бохирдол доройтлыг бууруулах, байгалийн нөөц, баялгийг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадамжтай үндэсний нийгэм, эдийн засгийн ногоон хөгжлийн загварыг бий болгоно” гэж тодорхойлсон байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хууль тогтоомж, эрх зүйн акт, бодлого, стратегийг төлөвлөх, боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй, сайд болон Засгийн газрын танхимд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдан эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Их хурлын 2025 оны 07 дугаар “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” тогтоолыг үндэслэн тус яам нь 9 газар, 10 хэлтэстэй, 122 орон тооны байсныг бүтцэд өөрчлөлт оруулан бууруулж, 7 газар, 5 хэлтэстэй, 111 орон тоотой байхаар баталсан байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай албан даалгавар”-ын дагуу зарим хөтөлбөр арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлсэн байна.

Тайлант онд дотоод аудитын нэгжээс төлөвлөгөөт 13 сэдвээр, төлөвлөгөөт бус 1 сэдвээр дотоод аудитыг гүйцэтгэж, давхардсан тоогоор 17 алба, нэгжид, нийт 148 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлснээс, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 37, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 36, нийт 73 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг 100.0 хувьтай биелүүлсэн гэж дүгнэсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлж, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан шинэчлэн боловсруулж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,251.5 мянган төгрөгөөр буюу 42.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,496,302.3	2,823,381.5	(672,920.8)
Авлага	458,515.8	553,793.9	95,278.1
Урьдчилгаа	17,066,503.4	15,929,562.8	(1,136,940.6)
Бараа материал	8,815,425.7	3,231,401.7	(5,584,024.0)
Нөөцийн бараа	34,558,523.6	1,450,846.3	(33,107,677.3)
Үндсэн хөрөнгө	6,050,551.2	6,205,376.0	154,824.8
Нийт хөрөнгө	70,445,822.0	30,194,362.2	(40,251,459.8)
Өр төлбөр	6,972,999.6	7,192,090.0	219,090.4
Засгийн газрын хувь оролцоо	63,472,822.4	23,002,272.2	(40,470,550.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	70,445,822.0	30,194,362.2	(40,251,459.8)

Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс өмнөх онуудад хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний баталгаат хугацаа дуусаж, 67,920.1 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлж, 2,823,381.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс өмнөх онуудад хэрэгжүүлсэн 1,193,565.7 мянган төгрөгийн отоглох цэг барих ажлыг тайлант онд хүлээн авч, зардалд хүлээн зөвшөөрсөн нь үлдэгдэл 15,929,562.8 мянган төгрөг болоход голлон нөлөөлсөн байна.

Бараа материалын үлдэгдэл 5,584,024.0 мянган төгрөгөөр буурахад дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэлтэй Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос өмнөх онуудад хэрэгжүүлсэн зарим аймгийн Дулааны цахилгаан станцад шүүлтүүр суурилуулах, хийн халаагуур, төвийн дулааны шугам сүлжээний ажил, бараа, үйлчилгээний ийт 5,522,460.8 мянган төгрөгийг холбогдох баримтыг үндэслэн ашиглагч талуудад шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 1,450,846.3 мянган төгрөг болж 33,107,677.3 мянган төгрөгөөр буурахад Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос өмнөх онуудад хэрэгжүүлсэн гэр хорооллын 5012 өрхийг 4 квт цахилгаан халаагуур ашиглах техникийн боломж бүрдүүлэх Багц: 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 10, 11, 12 эрчим хүчний ажлын, мөн аймгуудын Дулаан цахилгаан станцын шүүлтүүр суурилуулах болон зуухны яндангийн утааны шүүлтүүр, цонхны шүүлтүүр нано тор, газрын гүний дулааны насос, нам даралтын зуухыг хийн зуухаар солих, аймгуудын нам даралтын зуухны утаа шүүгч зэрэг нийт 33,096,657.7 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг хүлээн авч ашиглагч байгууллагуудад шилжүүлсэн нь нөлөөлжээ

Үндсэн хөрөнгө худалдан авсан 106,039.0 мянган төгрөг, татан буугдсан Байгаль орчин, уур амьсгалын сангаас 799,384.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 858 дугаар тогтоолын дагуу акталсан 970 нэрийн 982,894.7 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 23,002,272.2 мянган төгрөг болж буурахад тайлант үеийн үр дүн 40,001,821.9 мянган төгрөгийн сөрөг үзүүлэлттэй гарснаас шалтгаалжээ. голлон нөлөөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр өмнөх онуудад хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний барьцаа баталгааны 5.0 хувийг давхардуулан бүртгэснийг буцаан залруулж 453,909.7 мянган төгрөгөөр өмнөх үеийн үр дүнг бууруулсан байна.

Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны программ хангамжид 2025 онд Ай Ти Зон ХХК-аас тендер сонгон шалгаруулалтаар худалдан авсан "Fortinet Firewall" албан ёсны лицензийн 75,600.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус яам нь 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 53,514,991.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон, дээд шатны төсвийн захирагчид

хүргүүлсэн саналыг хянан бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 46.9 хувиар бууруулж 28,373,725.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны тодотголоор Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн зардлыг 4,316,978.3 мянган төгрөгөөр, Ойжуулалт хөтөлбөрийн зардлыг 2,488,925.0 мянган төгрөгөөр, Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн зардлыг 511,242.2 мянган төгрөгөөр, Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ хөтөлбөр буюу Мазаалай, нэн ховор амьтад хамгаалах зардлыг 385,759.2 мянган төгрөгөөр, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр буюу яамны урсгал зардлыг 436,403.00 мянган төгрөгөөр тус тус бууруулж төсвийг нийт 20,244,417.7 мянган төгрөг болгон 28.6 хувиар бууруулж тодотгосон байна.

Төсөв захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 166 арга хэмжээний 13,730,948.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 14,267,437.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бараа үйлчилгээний бусад зардалд 13,543,475.4 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 187,473.1 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 536,489.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,730,948.4 мянган төгрөг буюу 67.8 хувьтай байгаа нь улсын төсвөөс олгох санхүүжилт дутуу олгогдсоноос агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлыг 3,351,102.7 мянган төгрөг, мазаалай баавгайг хамгаалах хөтөлбөрийн зардлыг 1,731,575.3 мянган төгрөг, газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрийн зардлыг 783,606.4 мянган төгрөг, хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн зардлыг 647,184.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
	Нийт дүн	20,244,417.7	13,730,948.4	6,513,469.3	67.8
71403	Ойжуулалт	3,856,075.0	3,856,074.9	0.1	100.0
71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн	750.0	750.0	-	100.0
71407	Агаар, орчны бохирдлыг бууруулах	5,010,621.7	1,659,519.0	3,351,102.7	33.1
71410	Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх	2,048,757.8	1,265,151.4	783,606.4	61.8
71411	Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтол	7,489,772.4	6,842,587.6	647,184.8	91.4
71412	Мазаалай баавгайг хамгаалах	1,838,440.8	106,865.5	1,731,575.3	5.8

Эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгаврын 1.4.5-д “төрийн байгууллагын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх” гэж заасны дагуу зарим хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлсэнтэй холбоотой Агаар, орчны бохирдлыг бууруулах болон Мазаалай баавгайг хамгаалах хөтөлбөрийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

Монгол Улсын Их хурлын 2025 оны 07 дугаар “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” тогтоолыг үндэслэн тус яам нь 9 газар, 10 хэлтэстэй, 122 орон тооны байсныг бүтцэд өөрчлөлт оруулан орон тоог 9.0 хувиар бууруулж, 7 газар, 5 хэлтэстэй, 111 орон тоотой байхаар баталж, мөрдсөн байна.

Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 351 дүгээр тушаалаар албан хаагчдад өдөрт хоолны хөнгөлөлт 33.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 2.0 мянган төгрөг, нийт 35.0 мянган төгрөгийг олгохоор баталсан ба гүйцэтгэлээр хоол, унааны хөнгөлөлтөд 771,201.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хөтөлбөрийн зардлаас 23 удаагийн гадаад томилолтын зардалд 328,073.0 мянган төгрөг, тийзийн төлбөрт 576,937.3 мянган төгрөг, нийт 905,010.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

"Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ийг олон нийтэд сурталчлах ажилд 4 телевиз, 29 сайтад нийт 349,920.0 мянган төгрөгийг олгохоор баталж, 32 хэвлэл, мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 284,764.0 мянган төгрөгийг олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайланг гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Гадаад харилцааны яамнаас Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах зардлын санхүүжилт 785,912.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 196,227.9 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс хүлээн авсан орлого 17,148.3 мянган төгрөг, нийт 999,289.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 793,977.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 205,311.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Урсгал зардлаас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/241, А/643, А/700 дугаар тушаалаар тус яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй олон нийтийн үйлчилгээнд зориулсан ариун цэврийн байгууламж худалдан авах төсөл арга хэмжээг Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас зөөврийн ариун 4 тендерийг зарласнаас, Оффроад трэйвэл ХХК нь 4 удаа шалгарч 150,000.0-500,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, нийт 1,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн яамны үйл ажиллагааг сайжруулах, авлагын үлдэгдлийн тооцоог нийлж баталгаажуулах, урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэлтэй сөрөг дүнтэй үлдэгдлийг залруулах, жуулчдын отоглох цэгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зэрэг өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор О.Баярмаа гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Э.Энхбаатар, дараагийн шатны чанарын хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/470 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлан дахь сонгосон суурь үзүүлэлтээс 1.0 хувиар тооцож 297,088.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээний үр дүн хангалтгүй байна. Үүнд:

1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хэрэгцээнд Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2021 онд үйлдвэрлэсэн 230,759.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй, "Toyota Land Cruiser J300" маркийн, 1754 УНС улсын дугаартай автомашинд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй;
2. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр төслөөс шилжүүлсэн "Toyota Land Cruiser-200" маркийн 2181 УНР улсын дугаартай туулах чадвар өндөртэй автомашиныг албан хэрэгцээнд ашиглаж байгаа боловч бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2.4-т " ... үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 1.2-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасныг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 2 ширхэг авто тээврийн хэрэгсэлд бусдаас ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчлийг арилгаж, төслөөс ирсэн автомашиныг бүртгэж авах талаар эрх бүхий байгууллагад саналаа хүргүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 235,879.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 39,766,369.7 мянган төгрөгийн 183 мэдээллийг байршуулахаас 172 мэдээллийг хугацаанд нь, 26,446,824.6 мянган төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгадагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, томилолтын зардлын дансанд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгадагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар илрүүлсэн нийт 3,356,632.6 мянган төгрөгийн алдааг залруулах 14 зөвлөмж өгснөөс 2,724,141.5 мянган төгрөгийн 6 алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн өмнөх аудитаар алдаа зөрчлийг таслан зогсоох 367,022.8 мянган төгрөгийн 6 албан шаардлага, алдааг залруулах 53,097.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 74.9 хувьтай байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	6	367,022.8	6	367,022.8	85.0
Зөвлөмж	3	53,097.5	2	45,000.0	64.8
Нийт дүн	9	420,120.3	8	412,022.8	74.9

Өмнөх аудитаар өгсөн “Үндсэн хөрөнгөд бүртгэлгүй Тоёота Ланд круйзер 200 маркийн туулах чадвар өндөртэй автомашины засвар үйлчилгээ болон шатахууны зардалд нийт 8,097.5 мянган төгрөгийг зарцуулсан зөрчлийг давтан гаргахгүй байх” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Байгаль орчин, уур амьсгалын сан татан буугдсантай холбоотой хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг дараагийн аудитаар анхаарч, дахин нягтлах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,049,649.0 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил илэрснээс 959,456.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 90,192.4 мянган төгрөгийн алдааг залруулах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аудитаар баталгаажуулсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайлангийн жилийн эцсийн үлдэгдлээс 2025 оны эхний үлдэгдлийг 959,456.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлангийн төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг 204,209.6 мянган төгрөгөөр, бараа материалын үлдэгдлийг 7,541.2 мянган төгрөгөөр тус тус нэмсэн;

2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлогын дүнг 9,286.3 мянган төгрөгөөр бууруулж, үйл ажиллагааны зардлын дүнг 4,324.4 мянган төгрөгөөр нэмсэн;

3. Мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүнг 499,255.5 мянган төгрөгөөр нэмсэн, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 221,229.0 мянган төгрөгөөр бууруулсан;

4. Санхүүгийн байдлын тайлан, Санхүүгийн үр дүнгийн тайлан, Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан үр дүнг 13,610.6 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим"-ийн 5.1.2-т "тасралтгүй байх", 5.1.4-т "үнэн зөв байх", 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар баталгаажсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны төсвийн шууд захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнг өөрчилж, дараа оны эхний үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан зөрчлийг таслан зогоох албан шаардлага өгөв.

2. Бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Урьдчилж гарсан зардлын дансанд "Хайрхан наран трейд ХХК"-ийн 90,192.4 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг сөрөг дүнгээр илэрхийлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Урьдчилж гарсан зардлын дансны сөрөг дүнтэй үлдэгдлийг холбогдох баримтыг үндэслэн залруулах.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 15,113,889.6 мянган төгрөгийн 21 зөрчил² илэрсэнд 331,859.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 9,658,946.4 мянган төгрөгийн 14 албан шаардлага хүргүүлж, 5,123,083.8 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Үүнээс 1,576,937.2 мянган төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Төсвийн шууд захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 16,158,418.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг бөгөөд өргөн тархсан тул “**Сөрөг**” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2022 онд Могойн гол, Шарын гол нүүрсний уурхайг түшиглэн Завхан аймагт "Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр" байгуулахаар төлөвлөж Завхан аймгийн Засаг даргын Тамгын газартай ОББҮХ/2022-06, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газартай ОББҮХ/2022-37 дугаартай гэрээг тус тус байгуулсан боловч дээрх үйлдвэрийн барилгын ажлын хийгдээгүй ч Төрийн сангийн барьцаа хөрөнгийн 100900013353 дугаар дансанд 200,000.0 мянган төгрөгийг байршуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 онд гэрээ байгуулж хэрэгжүүлээгүй, төсөл арга хэмжээний барьцаа дансанд байршуулсан 200,000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2.Тус яамны нэр бүхий 1 албан хаагчийн хувийн харилцах дансанд "Өндөр түвшний зэрэгцээ арга хэмжээний зохион байгуулалтын зардал" гэх 82,069.0 мянган төгрөгийг шилжүүлж, бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан, Арабын Нэгдсэн Эмират болон Катар улсад томилолтоор ажилласан нэр бүхий 3 албан хаагчийн тийзийн төлбөрийг давхардуулан нийт 42,934.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн, Сайдын орон тооны бус зөвлөх 1 хүний гадаад томилолтын зардалд 5,122.4 мянган төгрөг зарцуулсан нийт 130,125.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, тийзийн төлбөрийг илүү тооцсон, сайдын орон тооны бус зөвлөхөд томилолт, тийзийн төлбөрийг олгосон зэрэг зөрчлийн нийт 130,125.4 мянган төгрөгийг нэр бүхий 4 албан хаагчаар төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлыг зохион байгуулах Үндэсний хорооны ажлын албаны урсгал төсвөөс Бүгд Найрамдах Кени улсын Найроби хотноо зохион байгуулсан гадаад арга хэмжээний бэлэг дурсгалын зардалд зарцуулсан 1,734.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим"-ийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг хүлээн зөвшөөрч бэлэг дурсгалын материалын зардалд зарцуулах 2025 оны А/14 дугаар тушаал гаргасан Үндэсний хорооны ажлын албаны даргаар төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас төсвийн төсөлд тусгаагүй, худалдан ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй зөөврийн ариун цэврийн байгууламжид нийт 1,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, барьцаа баталгааг байршуулаагүй зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Увс аймаг үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойгоор аймгийг зорин ирэх иргэд, жуулчдын ая тухыг хангах зорилгоор Увс аймгийн Засаг даргаас ариун цэврийн байгууламж, зөөврийн эко жорлон авахад зориулж 600,000.0 мянган төгрөгийн дэмжлэг хүссэний дагуу төсвийн төсөлд тусгаагүй, худалдан ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй зөөврийн ариун цэврийн байгууламж худалдан авах 4 тендерийг зарлаж, Оффроад трэйвэл ХХК 4 удаа шалгарч 150,000.0-500,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, нийт 1,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас олгосон байна.
2. Оффроад трэйвэл ХХК нь чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах, гэрээний үнийн дүнгийн 5.0 хувь буюу 50,000.0 мянган төгрөгийн барьцааг байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 42.5-д "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн төсөвт тусгаагүй, худалдан ажиллагааны төлөвлөгөөнд батлаагүй хөрөнгийг бэлтгэсэн, гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа, зүгшрүүлэх тохируулах хугацааны чанарын баталгааг байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Гадаад томилолтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөтөлбөрийн зардлаас гадаад томилолтын зардалд нийт 993,525.1 мянган төгрөгийг зарцуулснаас 576,937.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. Судалгаа болон харьцуулалтгүй онгоцны тийзийн үйлчилгээ, зуучлан борлуулдаг 6 аж ахуйн нэгж байгууллагатай шууд гэрээ байгуулж, тийзийн төлбөрт 429,411.6 мянган төгрөгийг олгосон;

- Гадаад томилолтоор Арабын Нэгдсэн Эмират, Катар улсад ажилласан 14 ажилтны тийзийн төлбөрт нийт 147,525.6 мянган төгрөгийг судалгаа болон харьцуулалтгүй "Аялал, жуулчлалын агентлаг, аяллын оператор болон захиалгат бусад үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг" Тапа Трип Эжэнси ХХК-д шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Судалгаа болон харьцуулалтгүй шууд гэрээ байгуулж тийзийн төлбөрт нийт 576,937,260.00 төгрөгийг олгосон, мөн тийзийн төлбөрийг хэт өндөр үнээр тооцож, шилжүүлсэн зэрэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

3. Гадаад томилолтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Гадаад томилолтын зардлаас гадны байгууллагын ажилтан, алба хаагчийн томилолт, тийзийн төлбөрт нийт 135,123.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- Тус яамны харьяа бус бусад байгууллагын 4 алба хаагчийн гадаад томилолт, тийзийн төлбөрт 66,468.2 мянган төгрөгийг;
- Улсын Их Хурлын 3 гишүүний гадаад томилолт, тийзийн төлбөрт 68,655.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөтөлбөрийн зардлаас бусад байгууллагын ажилтнуудын гадаад томилолт, тийзийн төлбөрийг төлсөн, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4. Хэвлэл мэдээллийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд тендер сонгон шалгаруулалтгүй хэвлэл, мэдээллийн байгууллагатай шууд гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 284,764.0 мянган төгрөгийг олгосон, зарим байгууллага гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн зэрэг зөрчил илэрсэн. Үүнд:

- Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/231 дүгээр тушаалаар ойжуулалтын хөтөлбөрөөс "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ийг олон нийтэд сурталчлах ажилд 4 телевиз, 29 сайтад нийт 349,920.0 мянган төгрөгийг олгохоор баталж, тендер сонгон шалгаруулалтгүй 32 хэвлэл, мэдээллийн байгууллагатай шууд гэрээ байгуулж, гүйцэтгэлээр ойжуулалтын хөтөлбөрөөс 226,114.0 мянган төгрөг, газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрөөс 58,650.0 мянган төгрөг, нийт 284,764.0 мянган төгрөгийг олгосон;
- Гүрэн ньос медиа групп ХХК, Гэрэл плас медиа холдинг ХХК, Таурус ХХК зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагад гэрээний нийт санхүүжилтийн 70.0 хувь буюу 55,809.0 мянган төгрөгийг олгосон боловч гүйцэтгэсэн ажлын тайланг ирүүлээгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай

тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 10.10-д “Засгийн газрын бодлого, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт болон цаг үеийн шинжтэй мэдээллийг яаралтай олон нийтэд хүргэх, мэдээлэхэд шаардлагатай хэвлэл мэдээллийн үйлчилгээ, Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой үндэсний үнэт зүйл, соёлын өвийг таниулсан соёл, урлагийн арга хэмжээ, тоглолт, урлагийн бүтээлийг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхгүй байж болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг олон нийтэд сурталчлах ажилд тендер сонгон шалгаруулалтгүй хэвлэл, мэдээллийн байгууллагатай шууд гэрээ байгуулсан, мөн бусад хөтөлбөрөөс хэвлэл, мэдээллийн гэрээний үлдэгдэл төлбөрийг олгосон, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулдаггүй зэрэг зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

5. Урьдчилж гарсан зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэлтэй 1-ээс дээш жилийн насжилттай, 4 аж ахуйн нэгж байгууллагын нийт 3,927,040.5 мянган төгрөгийн, мөн өмнөх онуудад хэрэгжүүлсэн хөтөлбөрийн зарим ажлын үр дүнг тооцоогүй, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон 23 аж ахуйн нэгж байгууллагын нийт 728,060.1 мянган төгрөгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэлтэй 1-ээс дээш жилийн насжилттай, төсөл арга хэмжээний үр дүнг тооцож, асуудлыг шийдвэрлэх, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

6. Бусад эргэлтийн хөрөнгийн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй худгийн 3 байшин, газар доорх зоорь, гүний худаг, ёмкость, техникийн байшин, ариун цэврийн байгууламж зэрэг 10 нэр төрлийн 503,285.1 мянган төгрөгийн хөрөнгө оршин байгаа нь тодорхойгүй, жилийн эцсийн тооллогоор биетээр тоологдоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй зарим хөрөнгүүд биетээр тоологдоогүй, оршин байгаа нь тодорхойгүй хөрөнгүүдийн шилжүүлсэн шийдвэр байгаа эсэхийг тодорхойлж, алга болсон хөрөнгийг эд хариуцагчаар төлүүлэх арга хэмжээ авах, албан шаардлагыг хүргүүлсэн.

7. Дуусаагүй үйлдвэрлэлийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд орчны бохирдлыг бууруулахаар 2020-2021 онд нэр бүхий 6 аймгийн сумд, Нийслэлийн Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлсэн аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулах барих 1,386,778.1 мянган төгрөг, лаг шатаах үйлдвэр барих 406,104.7 мянган төгрөг, нийт 1,792,882.8 мянган төгрөгийн дуусаагүй ажил бүртгэлтэй, гэрээний хугацаа дууссан боловч гэрээт ажлыг дуусгуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”-ийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо

хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх өмнөх онуудын зарим аймаг, нийслэлийн дүүрэг дэх гэрээний хугацаа дууссан аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулах, лаг шатаах үйлдвэр барих ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж, хүлээлцэн гэрээг дүгнэж, ашиглагч байгууллагад шилжүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

8. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Авлага дансны үлдэгдэлд 3 төрийн байгууллага, 2 аж ахуйн нэгжтэй холбоотой 3 жилээс дээш насжилттай, нийт 299,688,1 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх олон жилийн насжилттай, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

9. Өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагад төлөх өглөгийн дансанд хөрөнгө бэлтгэхтэй холбоотой нэр бүхий 6 төрийн байгууллагын нийт 312,056.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэр бүхий байгууллагуудтай тооцоо нийлж, өрийн асуудлыг шийдвэрлэх албан шаардлагыг хүргүүлсэн.

10. Үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлыг зохион байгуулах Үндэсний хорооны ажлын албаны урсгал зардлаас тендер сонгон шалгаруулалтгүй 30,330.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтер, 26,278.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, нийт 56,608.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Урсгал зардлаас тендер сонгон шалгаруулалтгүй, үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ худалдан авах ажиллагааны аргыг сонголгүй шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн.

11. Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/47 дугаар тушаалаар Богдхан уулын дархан цаазат газрын Нүхтийн амны хязгаарлалтын бүсэд байрлах 3.9 га буюу 39000 м.кв газрыг "Цөлжилттэй тэмцэх Монгол-Хятадын хамтын ажиллагааны төв"-ийг байгуулах зорилгоор ашиглах эрхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн олгосон боловч газрыг үнэлж яамны данс бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх ашиглах эрхтэй 3.9 га газрыг үнэлж данс бүртгэлд тусгах– албан шаардлагыг хүргүүлсэн.

12. Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сэлгэн ажиллах гэрээгээр ажиллаж байгаа "Төрийн захиргааны удирдлагын газрын дарга"-д цалингийн зөрүүг олгох зорилгоор нууц хамгаалах ажилтны нэмэгдлийг холбогдох тушаал шийдвэргүй 9-11 дүгээр сарын хугацаанд 3,103.0 мянган төгрөг, мөн 12 дугаар сард ээлжийн амралт биеэр эдлээгүйд тооцож 1,034.4 мянган төгрөг, нийт 4,137.6 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журмын 4.1-д "Нууц хамгаалах ажилтнаас бусад нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд нууц хамгаалах ажилтны цалингийн нэмэгдэл олгохыг хориглоно" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчийн цалин, ээлжийн амралтын тооцоог үндэслэлгүй тооцсон зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн.

13. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд нийт 38,363.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал:

1. Тус яам оффиссын байраа өөрчлөн 2 удаа нүүж, шилжихдээ анх худалдан авсан байранд суурилуулсан нийт 6,563.0 мянган төгрөгийн үнэтэй 121 м.кв угсардаг дрожийг салган ашиглах боломжгүйгээс уг байранд үлдээж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, мөн бараа материалын данснаас хасалт хийгээгүй;
2. Тайлант хугацаанд Засгийн газрын 12 дугаар байрны 2 оффисын өрөөний урсгал зардалд 19,420.0 мянган төгрөгийг зарцуулсан ч уг байрнаас нүүсэн;
3. Урсгал зардлаас бэлэг дурсгалын зүйлс болон соёмботой аяга худалдан авахад 6,070.0 мянган төгрөг, захиалгат мазаалай шоколад бэлтгэхэд 5,610.0 мянган төгрөг, нэрийн хуудас хэвлүүлэхэд 700.0 мянган төгрөг, нийт 12,380.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Урсгал зардлаас бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан, батлагдсан төсвийг зориулалтын бусаар, үр ашиггүй зарцуулсан зэрэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

14. Бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх онуудад Хьюндай Соната-7 маркийн 22-28 УБҮ дугаартай 32,387.0 мянган төгрөгийн балансын үнэтэй, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн, үлдэх өртөггүй автомашиныг дуудлага худалдаагаар зарах шийдвэр гарч зарсан гэх боловч данс, бүртгэлээс хасаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй зарим автомашиныг харьяа байгууллагуудад холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй ашиглуулж байгаа, дуудлага худалдаагаар зарсан автомашиныг данс бүртгэлээс хасаагүй зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд төсөвт тусгаагүй, тооцоо судалгаагүй, тендер сонгон шалгаруулалтгүй "Хашаандаа 5 мод таръя" аяныг зохион байгуулахад нийт 5,000,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 3,507,184.6 мянган төгрөг олгосон байна. Үүнд:

1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/225 дугаар тушаалаар ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд төсөвт тусгаагүй, тооцоо судалгаагүй "Хашаандаа 5 мод таръя" аяныг зохион байгуулахад нийт 5,000,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар баталж, тендер сонгон шалгаруулалтгүй 265 аж ахуйн нэгжтэй мод тарих, 10 аж ахуйн нэгжтэй хяналт тавих, 7 аж ахуйн нэгжтэй сургалт зохион байгуулах 16,000.0-18,704.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, гүйцэтгэл гараагүй байхад гэрээний нийт дүнгийн 70.0 хувь буюу 3,507,184.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон;
2. Гүйцэтгэлээр 308,280.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан нэр бүхий 25 аж ахуйн нэгж байгууллага нь гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Аяныг үр дүнтэй хэрэгжүүлж үр дүнг тооцох, мод тарих болон хяналт хэрэгжүүлэх аж ахуйн нэгжүүдийг нээлттэй сонгон шалгаруулж гэрээний үүргийн биелэлтийг хангуулж ажиллах.

2. Гадаад томилолтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус яамны нэр бүхий 8 ажилтан гадаад томилолтоор ажиллаж 67,345.6 мянган төгрөгийг зарцуулсан боловч ажлаас чөлөөлөгдөж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах талаар арга хэмжээг авч, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Авлагын дансанд Ус, цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс авах 50,618.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй боловч тус байгууллага нь яаманд төлөх өглөг байхгүй гэсэн шалтгаанаар авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авах эсэх нь тодорхойгүй авлага байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага, өглөг үүссэн эсэхийг анхан шатны баримттай тулган шалгаж, авлага, өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулах.

4. Төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус яамны үндсэн хөрөнгөд бүртгэлгүй суудлын 2 автомашиныг албан хэрэгцээнд ашиглаж нийт 5,120.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна. Үүнд:

1. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр төслөөс шилжүүлсэн "Toyota Land Cruiser-200" маркийн 2181 УНР улсын дугаартай туулах чадвар өндөртэй автомашиныг албан хэрэгцээнд ашиглаж байгаа боловч данс бүртгэлд шилжүүлэн тусгаагүй, нийт 1,620.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан;
2. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хэрэгцээнд Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2021 онд үйлдвэрлэсэн 230,759.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй, "Toyota Land Cruiser J300"

маркийн, 1754 УНС улсын дугаартай автомашиныг ашиглаж, нийт 3,500.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах",

Өгсөн зөвлөмж: Тус яамны харьяа бусад байгууллагын автомашины албан хэрэгцээнд ашиглахгүй байх, төслөөс шилжүүлсэн хөрөнгийг бүртгэж авах талаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		Албан шаардлага	
							Залруулсан		Залруулаагүй					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урьдчилж гарсан зардлын дансанд "Хайрхан наран трейд ХХК"-ийн 90,192.4 мянган төгрөгийн хасах дүнтэй үлдэгдэлтэй байна.	1	90,192.4			1	90,192.4			1	90,192.4	1	90,192.4		
Аудитаар баталгаажуулсан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайлангийн жилийн эцсийн үлдэгдлээс 2025 оны эхний үлдэгдлийг 959,456.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.	1	959,456.6			1	959,456.6			1	959,456.6			1	959,456.6
Дүн	2	1,049,649.0			2	1,049,649.0			2	1,049,649.0	1	90,192.4	1	959,456.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2022 онд Могойн гол, Шарын гол нүүрсний уурхайг түшиглэн Завхан аймагт "Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр" байгуулахаар төлөвлөж Завхан аймгийн Засаг даргын Тамгын газартай ОББҮХ/2022-06, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газартай ОББҮХ/2022-37 дугаартай гэрээг тус тус байгуулсан боловч дээрх үйлдвэрийг байгуулаагүй, гэрээний санхүүжилт 200,000,000.00 төгрөг Төрийн сангийн барьцаа хөрөнгийн 100900013353 дугаар дансанд үлдэгдэлтэй хэвээр байна.	1	200,000.0	1	200,000.0								
2	1. Тус яамны нэр бүхий 1 албан хаагчийн хувийн харилцах дансанд "Өндөр түвшний зэрэгцээ арга хэмжээний зохион байгуулалтын зардал" гэх 82,068,990.00 төгрөгийг шилжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу хангалтгүй; 2. Арабын Нэгдсэн Эмират, Катар улсад томилолтоор ажилласан нэр бүхий 3 албан хаагчийн тийзийн төлбөрийг давхардуулан нийт 42,934,000.00 төгрөгийг илүү шилжүүлсэн; 3. Сайдын орон тооны бус зөвлөх 1 хүний гадаад томилолтын зардалд 5,122,382.8 төгрөг, нийт 130,125,373. 0 төгрөгийн зөрчил илэрсэн.	1	130,125.4	1	130,125.4								

3	Үндэсний хорооны ажлын албаны урсгал төсвөөс Бүгд Найрамдах Кени улсын Найроби хотноо зохион байгуулсан гадаад арга хэмжээний бэлэг дурсгалын зардалд 1,734.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон.	1	1,734.0	1	1,734.0							
4	1. Увс аймаг үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойгоор аймгийг зорин ирэх иргэд, жуулчдын ая тухыг хангах зорилгоор Увс аймгийн Засаг даргаас ариун цэврийн байгууламж, зөөврийн эко жорлон авахад зориулж 600,000.0 мянган төгрөгийн дэмжлэг хүссэн боловч төсвийн төсөлд тусгаагүй, худалдан ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй зөөврийн ариун цэврийн байгууламж авах тендерийг зарлаж, Оффроад трэйвэл ХХК 4 удаа шалгарч 150,000.0-500,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, нийт 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас олгосон байна. 2. Оффроад трэйвэл ХХК нь чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах, гэрээний үнийн дүнгийн 5.0 хувь буюу 50,000.0 мянган төгрөгийн барьцааг байршуулаагүй байна.	1	1,000,000.0			1	1,000,000.0				1	1,000,000.0
5	Газрын доройтол, цөлжилтийг бууруулах хөтөлбөрийн зардлаас гадаад томилолтын зардалд нийт 993,525.1 мянган төгрөгийг зарцуулснаас 576,937.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. 1. Судалгаа болон харьцуулалтгүй онгоцны тийзийн үйлчилгээ, зуучлан борлуулдаг 6 аж ахуйн нэгж байгууллагатай шууд гэрээ байгуулж, тийзийн төлбөрт 429,411.6 мянган төгрөгийг олгосон; 2. Гадаад томилолтоор Арабын Нэгдсэн Эмират, Катар ажилласан 14 ажилтны тийзийн төлбөрт нийт 147,525.6 мянган төгрөгийг судалгаа болон харьцуулалтгүй "Аялал, жуулчлалын агентлаг, аяллын оператор болон захиалгат бусад үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг" Тапа Трип Эжэнси ХХК-д шилжүүлсэн байна.	1	576,937.2			1	576,937.2				1	576,937.2
6	1. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/231 дүгээр тушаалаар ойжуулалтын хөтөлбөрөөс "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ийг олон нийтэд сурталчлах ажилд 4 телевиз, 29 сайтад нийт 349,920.0 мянган төгрөгийг олгохоор баталж, тендер сонгон шалгаруулалтгүй 32 хэвлэл, мэдээллийн байгууллагатай шууд гэрээ байгуулж, гүйцэтгэлээр ойжуулалтын хөтөлбөрөөс 226,114.0 мянган төгрөг, газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрөөс 58,650.0 мянган төгрөг, нийт 284,764.0 мянган төгрөгийг олгосон байна. 2. Гүрэн ньюс медиа групп ХХК, Гэрэл плас медиа холдинг ХХК, Таурус ХХК зэрэг хэвлэл мэдээллийн байгууллага нь гэрээний нийт санхүүжилтийн 70.0 хувь буюу 55,809.0 мянган төгрөгийг авсан боловч гүйцэтгэсэн ажлын тайланг ирүүлээгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.	1	284,764.0			1	284,764.0					
7	Гадаад томилолтын зардлаас гадны байгууллагын ажилтан, алба хаагчийн томилолт, тийзийн төлбөрт нийт 135,123.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	135,123.3			1	135,123.3					
8	Урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэлтэй 1-ээс дээш жилийн насжилттай, татан буугдсан төрийн өмчит хуулийн этгээд болон 4 хувийн өмчит хуулийн этгээдийн нийт 3,927,040.5 мянган төгрөгийн, мөн өмнөх онуудад хэрэгжүүлсэн хөтөлбөрийн зарим ажлын үр дүнг тооцоогүй, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон 23 аж ахуйн нэгж байгууллагын нийт 728,060.1 мянган төгрөгийн асуудлыг	1	4,655,100.6			1	4,655,100.6					

	шийдвэрлүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.												
9	Бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэлтэй худгийн байшин 3 ширхэг, газар доорх зоорь, гүний худаг, емкость, техникийн байшин, ариун цэврийн байгууламж зэрэг 10 нэр төрлийн 503,285.1 мянган төгрөгийн хөрөнгө хаана байгаа нь тодорхойгүй, жилийн эцсийн тооллогоор биетээр тоологдоогүй байна.	1	503,285.1			1	503,285.1						
10	Дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд "Орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд 2020-2021 онд нэр бүхий 6 аймгийн сумд, Нийслэлийн Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлсэн аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын 1,386,778.1 мянган төгрөг, лаг шатаах үйлдвэрийн 406,104.7 мянган төгрөг, нийт 1,792,882.8 мянган төгрөгийн дуусаагүй ажлын үлдэгдэлтэй, гэрээний хугацаа дууссан боловч гэрээт ажлыг дуусгуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	1,792,882.8			1	1,792,882.8						
11	Авлага дансны үлдэгдэлд 3 төрийн байгууллага болон 2 аж ахуйн нэгжийн 3 жилээс дээш насжилттай, нийт 299,688.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.	1	299,688.1			1	299,688.1						
12	Байгууллагад төлөх өглөгийн дансанд хөрөнгө бэлтгэхтэй холбоотой нэр бүхий 6 төрийн байгууллагын нийт 312,056.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба өглөгийн тооцоог нийлж, барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.	1	312,056.7			1	312,056.7						
13	Үндэсний хорооны ажлын албаны урсгал зардлаас тендер сонгон шалгаруулалтгүй 30,330.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, принтер, 26,278.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, нийт 56,608.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан байна.	1	56,608.0			1	56,608.0						
14	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/47 дугаар тушаалаар Богдхан уулын дархан цаазат газрын Нүхтийн амны хязгаарлалтын бүсэд байрлах 3.9 га буюу 39000 м.кв газрыг "Цөлжилттэй тэмцэх Монгол-Хятадын хамтын ажиллагааны төв"-ийг байгуулах зорилгоор ашиглах эрхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн олгосон боловч яамны данс бүртгэлд тусгаагүй байна.	1	-			1	-						
15	Сэлгэн ажиллах гэрээгээр ажиллаж байгаа ажилтанд холбогдох тушаал шийдвэргүй нууцийн нэмэгдлийг 9-11 сар хүртэл 3,103.0 мянган төгрөг, 12 сард ээлжийн амралт биеэр эдлээгүйд тооцож 1,034.4 мянган төгрөг, нийт 4,137.6 мянган төгрөгийг олгосон.	1	4,137.6			1	4,137.6						
16	Тайлант онд нийт 12,380.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.	1	38,363.0			1	38,363.0						
17	Өмнөх онуудад Хьюндай Соната-7 маркийн 22-28 УБҮ дугаартай 32,387.0 мянган төгрөгийн балансын үнэтэй, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн, үлдэх өртөггүй автомашиныг акталж дуудлага худалдаагаар зарсан гэх боловч данс, бүртгэлээс хасаагүй байна.	1	-			1	-						

18	1.БОУАӨС-ын 2025 оны А/225 дугаар тушаалаар ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд төсөвт тусгагдаагүй, тооцоо судалгаагүй "Хашаандаа 5 мод таръя" аяныг зохион байгуулахад нийт 5.0 тэрбум төгрөгийг зарцуулахаар баталж, тендер сонгон шалгаруулалтгүй 265 аж ахуйн нэгжтэй мод тарих, 10 аж ахуйн нэгжтэй хяналт тавих, 7 аж ахуйн нэгжтэй сургалт зохион байгуулах 16,000.0-18,704.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, гүйцэтгэл гараагүй байхад гэрээний нийт дүнгийн 70.0 хувь буюу 3,507,184.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон; 2. Гүйцэтгэлээр 308,280.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан нэр бүхий 25 аж ахуйн нэгж байгууллага нь гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн.	1	5,000,000.0					1	5,000,000.0				
19	Авлагын дансанд УЦУОСМХ-ээс авах 50,618.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй боловч тус байгууллагад яаманд төлөх өглөгийн үлдэгдэл байхгүй байна.	1	50,618.2					1	50,618.2				
20	Нэр бүхий 8 ажилтан гадаад томилолтоор ажиллаж 67,345.6 мянган төгрөгийг зарцуулсан боловч ажлаас чөлөөлөгдөж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	67,345.6					1	67,345.6				
21	Тус яамны үндсэн хөрөнгөд бүртгэлгүй 2 ширхэг суудлын 2 автомашиныг албан хэрэгцээнд ашиглаж нийт 5,120.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна. Үүнд: 1.Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр төслөөс шилжүүлсэн "Toyota Land Cruiser-200" маркийн 2181 УНР улсын дугаартай туулах чадвар өндөртэй автомашиныг албан хэрэгцээнд ашиглаж байгаа боловч данс бүртгэж шилжүүлэн аваагүй, нийт 1,620.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан; 2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны албан хэрэгцээнд Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2021 онд үйлдвэрлэсэн 230,759.3 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй, "Toyota Land Cruiser J300" маркийн, 1754 УНС улсын дугаартай автомашиныг ашиглаж, нийт 3,500.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.	1	5,120.0					1	5,120.0				
Дүн		21	15,113,889.6	3	331,859.4	14	9,658,946.4	4	5,123,083.8			2	1,576,937.2

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/					
	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>						
БОУАӨС-ын албан хэрэгцээнд Богдхан уулын ДЦГХЗ-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй "Toyota land cruiser J300" маркийн, 1754 УНС улсын дугаартай автомашиныг ашиглаж, нийт 3,500.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан, мөн бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй.	1	-	1	-		
НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр төслөөс өгсөн "Toyota land cruiser-200" маркийн, 2181 УНР улсын дугаартай автомашиныг албан хэрэгцээнд ашиглаж, нийт 1,620.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан, мөн бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.						
Дүн	1	-	1	-		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 33/A0160066

Улаанбаатар хот

САГ-2026/23/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2022 онд Могойн гол, Шарын гол нүүрсний уурхайг түшиглэн Завхан аймагт "Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр" байгуулахаар төлөвлөж Завхан аймгийн Засаг даргын Тамгын газартай ОББҮХ/2022-06, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газартай ОББҮХ/2022-37 дугаартай гэрээг тус тус байгуулсан боловч дээрх үйлдвэрийг байгуулаагүй, гэрээний санхүүжилт 200,000,000.00 /хоёр зуун сая/ төгрөг Төрийн сангийн барьцаа хөрөнгийн 100900013353 дугаар дансанд үлдэгдэлтэй хэвээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2 дугаар зүйлийн 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 онд хэрэгжүүлээгүй, төсөл арга хэмжээний барьцаа дансанд байршуулсан 200,000,000.00 /хоёр зуун сая/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Батбаяр/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Чулуунчимэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

9806169
АТГ-14627
9025031411

D:\My Works\New Folder - Copy\0225 SAG-4. (1).Docx

1526200039



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 34/A0160066

Улаанбаатар хот

САГ-2026/23/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус яамны нэр бүхий 1 албан хаагчийн хувийн харилцах дансанд "Өндөр түвшний зэрэгцээ арга хэмжээний зохион байгуулалтын зардал" гэх 82,068,990.00 /наян хоёр сая жаран найман мянга есөн зуун ерэн/ төгрөгийг шилжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэл дутуу хангалтгүй;
2. Арабын Нэгдсэн Эмират, Катар улсад томилолтоор ажилласан нэр бүхий 3 албан хаагчийн тийзийн төлбөрийг давхардуулан нийт 42,934,000.00 /дөчин хоёр сая есөн зуун гучин дөрвөн мянган/ төгрөгийг илүү шилжүүлсэн;
3. Сайдын орон тооны бус зөвлөх 1 хүний гадаад томилолтын зардалд 5,122,383.00 /таван сая нэг зуун хорин хоёр мянга гурван зуун наян гурав/ төгрөг, нийт 130,125,373.00 /нэг зуун гучин сая нэг зуун хорин таван мянга гурван зуун далан гурван/ төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2 дугаар зүйлийн 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**


Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Arh\2026\0225.SAG-4. (1).Docx

1526200055

1. Гадаад томилолтын зардлын зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдэл дутуу, тийзийн төлбөрийг илүү тооцож олгосон, сайдын орон тооны бус зөвлөхөд томилолт, тийзийн төлбөрийг олгосон зэрэг зөрчлийн нийт 130,125,373.00 /нэг зуун гучин сая нэг зуун хорин таван мянга гурван зуун далан гурван/ төгрөгийг хавсралтад дурдсан нэр бүхий 4 албан хаагчаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Батбаяр/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Чулуунчимэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР АУДИТЫН МЕНЕЖЕР АХЛАХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ Э.ЭНХБААТАР О.БАЯРМАА
---	---	--

Үндэсний аудитын газрын
2026 оны 09 дугаар сарын 25-ны
өдрийн 31/40160066 дугаар
актын хавсралт

Актын төлбөрийг барагдуулах жагсаалт

/төгрөгөөр/

Д/д	Актын төлбөрийг барагдуулах		Зөрчлийн утга	Төлөх дүн	Төлбөрийг барагдуулах хугацаа
	Алба хаагч, иргэний овог нэр	Албан тушаал			
1	Батчулууны Бат-Өлзий	БОУАӨЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга	Анхан шатны баримтын бүрдэлгүй, гадаад арга хэмжээний зардал	82,068,990.00	2026.09.30
	Дүн			82,068,990.00	
2	Дондовдоржийн Батмөнх	Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын Конвенцын талуудын 17 дугаар Бага хурлыг зохион байгуулах Үндэсний хорооны ажлын албаны дарга	УБ-Бээжин-Дубай-АбуДабу-Кувейт-Доха-Станбул-УБ маршрутаар явсан тийзийн төлбөр илүү шилжүүлсэн	12,491,400.00	2026.09.30
3	Батын Батбаатар	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	УБ-Бээжин-Дубай-АбуДабу-Кувейт-Доха-Станбул-УБ маршрутаар явсан тийзийн төлбөр илүү шилжүүлсэн	26,961,900.00	2026.09.30
4	Доржсүрэнгийн Ариунтуяа	БОУАӨЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга	УБ-Станбул-АбуДабу-Доха-Станбул-УБ маршрутаар явсан тийзийн төлбөр илүү шилжүүлсэн	3,480,700.00	2026.09.30
	Дүн			42,934,000.00	
1	Дүрэээгийн Одхүү	Сайдын орон тооны бус зөвлөх	Сайдын орон тооны бус зөвлөх 1 хүний гадаад томилолтын зардалд 5,122,383.00 /таван сая нэг зуун хорин хоёр мянга гурван зуун наян гурав/ төгрөгийг зарцуулсан.	5,122,383.00	2026.09.30
	Дүн			5,122,383.00	
	Нийт дүн			130,125,373.00	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 35/A0160066

Улаанбаатар хот

САГ-2026/23/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цөлжилттэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлыг зохион байгуулах Үндэсний хорооны ажлын албаны урсгал төсвөөс Бүгд Найрамдах Кени улсын Найроби хотноо зохион байгуулсан гадаад арга хэмжээний бэлэг дурсгалын зардалд 1,734,002.00 /нэг сая долоон зуун гучин дөрвөн мянга хоёр/ төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим"-ийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2 дугаар зүйлийн 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх анхан шатны баримтын бүрдэл дутуу олгосон, бэлэг дурсгалын материалын 1,734,002,00 /нэг сая долоон зуун гучин дөрвөн мянга хоёр/ төгрөгийг зардлыг гаргах 2025 оны А/14 дугаар тушаал гаргасан Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын Конвенцын талуудын 17 дугаар Бага хурлыг зохион байгуулах Үндэсний хорооны ажлын албаны дарга Д.Батмөнхөөр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх;


Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAG-2 Docx

1526200021

1. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Батбаяр/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Чулуунчимэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 209/AD160066

Улаанбаатар хот

САГ-2026/23/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Увс аймаг үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойгоор аймгийг зорин ирэх иргэд, жуулчдын ая тухыг хангах зорилгоор Увс аймгийн Засаг даргаас ариун цэврийн байгууламж, зөөврийн эко жорлон авахад зориулж 600,000,000.00 /зургаан зуун сая/ төгрөгийн дэмжлэг хүссэн боловч төсвийн төсөлд тусгаагүй, худалдан ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй зөөврийн ариун цэврийн байгууламж авах тендерийг зарлаж, Оффроад трэйвэл ХХК 4 удаа шалгарч 150,000.0-500,000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, нийт 1,000,000,000.00 /нэг тэрбум/ төгрөгийн санхүүжилтийг Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас олгосон байна.


2. Оффроад трэйвэл ХХК нь чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах, гэрээний үнийн дүнгийн 5.0 хувь буюу 50,000,000.00 /тавин сая/ төгрөгийн барьцааг байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 42.5-д "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн төсөвт тусгаагүй, худалдан ажиллагааны төлөвлөгөөнд батлаагүй хөрөнгийг бэлтгэсэн, гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа, зүгшрүүлэх тохируулах хугацааны чанарын баталгааг байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Батбаяр/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Чулуунчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 20/A016 0066

Улаанбаатар хот

САГ-2026/23/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн А/231 дүгээр тушаалаар ойжуулалтын хөтөлбөрөөс "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ийг олон нийтэд сурталчлах ажилд 4 телевиз, 29 сайтад нийт 349,920,000.00 /гурван зуун дөчин есөн сая есөн зуун хорин мянган/ төгрөгийг олгохоор баталж, тендер сонгон шалгаруулалтгүй 32 хэвлэл, мэдээллийн байгууллагатай шууд гэрээ байгуулж, гүйцэтгэлээр ойжуулалтын хөтөлбөрөөс 226,114,000.00 /хоёр зуун хорин зургаан сая нэг зуун арван дөрвөн мянган/ төгрөг, газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөрөөс 58,650,000.00 төгрөг, нийт 284,764,000.00 /хоёр зуун наян дөрвөн сая долоон зуун жаран дөрвөн мянган/ төгрөгийг олгосон байна.


2. Гүрэн ньус медиа групп ХХК, Гэрэл плас медиа холдинг ХХК, Таурус ХХК зэрэг хэвлэл мэдээллийн байгууллага нь гэрээний нийт санхүүжилтийн 70.0 хувь буюу 55,809,000.00 /тавин таван сая найман зуун есөн мянган/ төгрөгийг авсан боловч гүйцэтгэсэн ажлын тайланг ирүүлээгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.10-д "Засгийн газрын бодлого, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт болон цаг үеийн шинжтэй мэдээллийг яаралтай олон нийтэд хүргэх, мэдээлэхэд шаардлагатай хэвлэл мэдээллийн үйлчилгээ, Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан улсын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой үндэсний үнэт зүйл, соёлын өвийг таниулсан соёл, урлагийн арга хэмжээ, тоглолт, урлагийн бүтээлийг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхгүй байж болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тендер сонгон шалгаруулалтгүй хэвлэл, мэдээллийн байгууллагатай шууд гэрээ байгуулдаг, мөн бусад хөтөлбөрөөс хэвлэл, мэдээллийн гэрээний үлдэгдэл төлбөрийг олгосон, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулдаггүй зэрэг зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Батбаяр/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Чулуунчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 211/А0160066

Улаанбаатар хот

САГ-2026/23 /НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Газрын доройтол, цөлжилтийг бууруулах хөтөлбөрийн зардлаас гадаад томилолтын зардалд нийт 993,525,136.00 /есөн зуун ерэн гурван сая таван зуун хорин таван мянга нэг зуун гучин зургаа/ төгрөгийг зарцуулснаас 576,937,160.00 /таван зуун далан зургаан сая есөн зуун гучин долоон мянга нэг зуун жаран/ төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. Судалгаа болон харьцуулалтгүй онгоцны тийзийн үйлчилгээ, зуучлан борлуулдаг 6 аж ахуйн нэгж байгууллагатай шууд гэрээ байгуулж, тийзийн төлбөрт 429,411,560.00 /дөрвөн зуун хорин есөн сая дөрвөн зуун арван нэгэн мянга таван зуун жаран/ төгрөгийг олгосон;

2. Гадаад томилолтоор Арабын Нэгдсэн Эмират, Катарт ажилласан 14 ажилтны тийзийн төлбөрт нийт 147,525,600.00 /нэг зуун дөчин долоон сая таван зуун хорин таван мянга зургаан зуун/ төгрөгийг судалгаа болон харьцуулалтгүй "Аялал, жуулчлалын агентлаг, аяллын оператор болон захиалгат бусад үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг" Тапа Трип Эжэнси ХХК-д шилжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Судалгаа болон харьцуулалтгүй шууд гэрээ байгуулж тийзийн төлбөрт нийт 576,937,260.00 төгрөгийг олгосон, мөн тийзийн төлбөрийг хэт өндөр үнээр тооцож, шилжүүлсэн зэрэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Батбаяр/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Чулуунчимэг/, Цөлжилттэй тэмцэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын талуудын 17 дугаар Бага хурлыг зохион байгуулах Үндэсний хорооны ажлын албаны дарга Д.Батмөнх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
О.БАЯРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 212/А0160066

Улаанбаатар хот

САГ-2026/23/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус яамны харьяа бус бусад байгууллагын 4 иргэний гадаад томилолт, тийзийн төлбөрт 66,468,224.00 /жаран зургаан сая дөрвөн зуун жаран найман мянга хоёр зуун хорин дөрвөн/ төгрөг;
2. Улсын Их Хурлын 3 гишүүний гадаад томилолт, тийзийн төлбөрт 68,655,101.00 /жаран найман сая зургаан зуун тавин таван мянга нэг зуун нэг төгрөгийг, нийт 135,123,325.00 /нэг зуун гучин таван сая нэг зуун хорин гурван мянга гурван зуун хорин таван/ төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөтөлбөрийн зардлаас бусад байгууллагын ажилтнуудын гадаад томилолт, тийзийн төлбөрийг төлсөн, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Батбаяр/, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Чулуунчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

